



Татварын талаарх илэн далангүй яриа



Татварын шинэтгэл, түүнийг хаанаас эхлэх вэ? II хэсэг: Нэмэгдсэн өртгийн албан татвар

Монгол Улсын татварын бодлого монголын эдийн засгийн хөгжлийн хөшүүрэг болж чадаж байна уу?

Өнгөрсөн долоо хоногийн дугаарт аж ахуйн нэгж, байгууллагад учирч буй татварын дарамт, ялангуяа аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын дарамтыг бууруулахад анхаарвал зохих зарим асуудлуудыг авч хэлэлцсэн. Энэ удаагийн дугаарт нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) аж ахуйн нэгж, байгууллагад хэрхэн нөлөөлдгийг авч үзье.

Аливаа аж ахуйн нэгж, байгууллага нь бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа НӨАТ төлж, харин бүтээгдэхүүн борлуулахдаа НӨАТ-ыг цуглуулан авах бөгөөд тэдгээрийн зөрүүг төсөвт төлдөг. Тиймээс аж ахуйн нэгж, байгууллагад үүнээс үүдэн бодит зардал гарахгүй юм.

	<u>НӨАТ ороогүй дүн</u>	<u>НӨАТ-ын дүн (15%)</u>
Бараа, ажил, үйлчилгээний өртөг	300,000 төгрөг	45,000 төгрөг
Борлуулах үнэ	500,000 төгрөг	60,000 төгрөг
Төсөвт төлөх дүн (60,000 - 45,000)		15,000 төгрөг

Үнэн хэрэгтээ бизнес эрхлэгчдэд болон нийт эдийн засагт НӨАТ ихээхэн нөлөө үзүүлдэг.

Бизнес эрхлэгчдэд үзүүлэх нөлөө:

- НӨАТ-ын цэвэр "зардал" тэгтэй тэнцүү байх боловч худалдан авалтад төлсөн татварыг бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулах хүртэл нөхөх боломжгүй байдаг тул түүнийг санхүүжүүлэх зардал зайлшгүй гардаг. Зээлийн хүү өндөр байгаа нөхцөлд энэ нь дотоодын бизнес эрхлэгчдэд ихээхэн дарамт учруулж байна.
- НӨАТ төлөгчөөр бүртгүүлээгүй аж ахуйн нэгж, байгууллагууд худалдан авсан зүйлдээ НӨАТ төлдөг боловч өөрийн бүтээгдэхүүндээ уг татварыг тооцон борлуулах боломжгүй юм. Тиймээс эдгээр аж ахуйн нэгж, байгууллагуудын бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа төлсөн татварын өртөг нөхөгдөхгүй юм. Энэ нь жижиг бизнес эрхлэгчдийн томоохон бизнестэй өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж байна. Ялангуяа, шинээр бий болж буй аж ахуйн нэгж, байгууллагад эхний худалдан авах зүйлстээ НӨАТ төлөх нь хүндрэлтэй байдаг.

Эдийн засагт үзүүлэх нөлөө:

- Бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тохиолдол бүрт НӨАТ-ыг төлдөг тул аливаа аж ахуйн нэгж, байгууллагад НӨАТ-аас зугтах боломж бага байдаг. Өөрөөр хэлбэл, далд эдийн засагт оролцогч талууд албан эдийн засгаас худалдан авсан зүйлдээ НӨАТ төлөх шаардлагатай юм. Далд эдийн засагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад НӨАТ төлөгч байх нь ихээхэн ач холбогдолтой. Энэ нь уг талуудад татвар төлөгчөөр бүртгүүлэн албан эдийн засагт оролцох үндэс болдог.
- Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих эдийн засгийн хамгийн чухал хөшүүрэг нь НӨАТ юм. Учир нь бүх импортын бараанд НӨАТ ногдуулж, экспорт болон дотоодын зарим жижиг үйлдвэрлэгчдийг уг татвараас чөлөөлдөг. Энэ нь гадаадын бизнестэй өрсөлдөх боломжийг дотоодын бизнес эрхлэгчдэд олгож буй нэг хэлбэр юм.
- НӨАТ нь бизнесийн орчинд гарах бүх ажил, үйлчилгээг хамрах тул татварын бааз тогтмол бөгөөд татварын орлогын хэмжээ нь өндөр байдаг. Харин аж ахуйн нэгж, байгууллагад ногдуулж буй орлогын албан татварын бааз суурь нь тогтворгүй, татвараас зайлсхийх боломж их байдаг.
- Монгол улсын импортын хэмжээ харьцангуй өндөр байдгаас НӨАТ-ын ихэнх хувь (60 орчим)-ийг хил дээр хурааж авдаг. Тиймээс татвар хураалт, түүнтэй холбогдон гарах захиргааны зардлын хэмжээ НӨАТ-ын нийт дүнтэй харьцуулахад бага байна. Бусад татварын нэр төрлийн хувьд зардал өндөртэй боловч татварын орлогын хэмжээ нь харьцангуй бага байдаг.

Төр, засгийн зүгээс НӨАТ-ын тухай хуулийг шинэчлэхдээ олон хувилбарыг харгалзан үзэх шаардлагатай байгааг дээр дурьдсан зүйлс нотлон харуулж байна.

Энэхүү мэдээлэл нь татварын шинэтгэлийн талаар нийт ард иргэдийн санаа бодлыг сонсох зорилгоор Сангийн яам, Үндэсний Татварын Ерөнхий Газраас явуулж буй цуврал хэлэлцүүлгийн долоо дугаар хэсэг юм. Та бүхэн уг цувралын электрон хувилбарыг "Нээлттэй засаг" вэб сайт (www.open-government.mn), Сангийн яамны вэб сайт (www.mof.pmis.gov.mn), УТЕГ-ын вэб сайт (www.mta.mn)-аас үзэж, саналаа ирүүлж болно.